



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/150

Чингис хот

Ой хээрийн түймрийн гамшгийн эрсдэлийн
тойм судалгаа хийх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь хэсэг, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн ой хээрийн түймрийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Гишүүд	Б.Нямхатан	Байгаль орчин аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга
	Т.Нарангэрэл	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Мэдээлэл, үйлчилгээний хэлтсийн дарга
	Г.Мөнхсайхан	Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахлах дэслэгч
Нарийн бичиг:	С.Тэмүүжин	Хэрлэн сумын Байгаль орчны улсын хяналтын байцаагч
	Т.Мөнхчимэг	Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, хариуцсан мэргэжилтэн, дэслэгч

2. Ой, хээрийн гал түймрийн гамшгийн эрсдэлийн тойм судалгааг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан хийж дуусгахыг ажлын хэсэгт даалгасугай.

2.

3. Гамшгийн эрсдэлийн тойм судалгааны үр дүнг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлд танилцуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА